## БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2022 ОНЫ БИЕЛЭЛТ

2022.12.14 Өлгий сум

| Здүах-т тусгагдсан зорилт | № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ (сая төгрөг) | Суурь түвшин | 2022 оны хэрэгжилт: 2022 оны хүрэх түвшин | 2022 оны хэрэгжилт: Хүрсэн түвшин, үр дүн | Хэрэгжилт /хувь/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 3.2.1 Уул уурхайн салбарын үйл ажиллагаанаас байгаль орчинд сөрөг нөлөөллийг бууруулна. | 1 | Хариуцлагатай уул уурхайг дэмжих, уул уурхайн баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдийг байгуулахад хулийн хүрээнд дэмжиж ажиллана. | 2021-2024 | | | Тодорхой хэмжээнд нөхөн сэргээлт хийгдсэн байна. | Цэнгэл сумын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Эс Жи группын баригдаж байгаа байгуулах үйлдвэрийн үйл ажиллагаанд шалган зааварчлах ажлыг зохион байгуулж дэмжин ажиллаж байна. | 70% |
| | 2 | Аймгийн хэмжээнд уул уурхайн чигэлэлээр үйл ажиллагаа явуулж байгаа компаниудыг хуулийн хүрээнд бодлогоор дэмжиж, хяналт тавьж амтран ажиллана. | 2021-2024 | | 2021 оны байдлаар 6 аж ахуйн нэгж, компани хайгуулын үйл ажиллагаа явуулж байна. | | Тус аймагт 60 аж ахуйн нэгж тусгай зөвшөөрөл эзэмшиж байна. Үүнээс 30 ашиглалтын лицензтэй, 30 хайгуулын лицензтэй. 21 аж ахуйн нэгж, компани нь 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу сумдын ЗДТГазар, БОХУБайцаагч, байгаль хамгаалагч нар хяналт тавьж ажиллаж байна. | 70% |
| | 3 | Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлогч аж ахуйн нэгжүүдийг хуулийн хүрээнд бодлогоор дэмжиж, хяналт тавина. | 2021-2024 | | | | БОАЖГазар, Цагдаагийн газар, МХГазар, Өлгий сумын ЗДТГазар, Бугат сумын ЗДТГазартай хамтран баталсан удирдамжийн дагуу Ховд голын эрэгт тогтмол хяналт шалгалт хийж ажиллаж байна. Ажиллах явцад зөвшөөрөлгүй хайрга олборлосон 7 зөрчил илэрүүлж, зөрчлийг тус бүрийг харъяалалын дагуу | 100 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | МХГазарт шилжүүлсэн.<br><br>Хууль бусаар түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 24 цагийн постонд хувиарын дагуу гарч ажиллаж байгаа. Өлгий сумын байгаль хамгаалагчид багийн засаг дарга нартай хамтран 05 дугаар сарын 02-оос 06-р сарын 30-ны өдөр хүртэл тус сумын багуудад ус, түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглаж, үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэр, үйлчилгээний газруудын судалгааг гаргаж, төрийн хяналт шалгалтын тухай хууль, байгаль орчныг хамгаалах тухай хууль, зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгах зорилгоор ажиллаж байна.<br><br>2022 оны эхний 10 сарын байдалаар түгээмэл тархацтай ашигт малтмал олборлосон 29,1 га газарт 17.480.000 төгрөгөөр техникийн нөхөн сэргээлтийн ажил хийгдлээ.<br>Аймгийн Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/590 дугаар захирамжаар “Нурнама” ХХК-д ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл, “Си Ди Ти” ХХК-д түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулан тусгай зөвшөөрөл, “МЖЛ-Алтай” ХХК-д түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн тус тус олгов. | |
| | 4 | Уул уурхайн олборлолтын улмаас эвдэрсэн талбайн нөхөн сэргээлтийн ажлыг бүрэн хийлгэнэ. | | | | | Уул уурхайн олборлолтын үйл ажиллагааны улмаас аймгийн хэмжээнд 38.4 га газар байгаагаас Ногооннуур сумын хавслын ам гэдэг газарт бичил уурхай үйл ажиллагаа эрхэлдэг “Сунхар” нөхөрлөл нь 0.4 га газарт өөрийн | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хөрөнгөөр нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>Булгансумын Их жаргалантад “Бүркит” корпарацийн 24.3 га, Алтайн сумын Даваат, Сагсай ресурс минерал ХХк-ны 5 га газар нөхөн сэргээлт хийх албан шаардлага хүргүүлсэн байна. | |
| 3.4.1. Аймгийн нутаг дэвсгэрт аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого боловсруулан хэрэгжүүлнэ | 1 | Аймгийг аялал жуулчлалын бүс болгох боломжийг бүрдүүлнэ. | 2021-2024 | | | Бүс тогтоох судалгаа хийгдсэн байна. | Аймгийн Засаг даргын үүрэг, даалгавар өгсний дагуу тус аймгийн Байгаль, Түүх, Соёлын шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулж, аймгийн Засаг даргад хүргүүлж, 2022 оны 03-р сарын 22-ний өдөр Ерөнхий сайд Л. Оюун-Эрдэнэ танилцуулсны үндсэн дээр Соёлын аялал жуулчлалын 4-дэх бүс болгохоор зарлаж, тогтоолын төслийг БОАЖЯам Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын бодлогыг боловсруулж Засгийн газарт хүргүүлээд байна. | 70 % |
| | 2 | Өвлийн болон адал явдалт аялал жуулчлалыг хөгжүүлэхийг бодлогоор дэмжинэ. | 2022-2024 | Хувийн хэвшил, төсөл хөтөлбөр | Аялал жуулчлалын нэг төрлийн бүтээгдэхүүн байна. | | Аймгийн хэмжээнд БОАЖГазраас 2022 оноос хэрэгжих Бүргэдийн баяр, Алтайн нүүдэлчдийн баяр, Хаврын Бүргэдийн баяр, Мөсний баяр, Наурызын баяр, Алтайн Урианхайн мөсөн сур харваа, Цагаан сарын баяр, Казах үндэсний спортын их наадам, Монгол морин спортын их наадам, Алтай таван богд ууланд Экстрим аялал нийт 10 нь эвент арга хэмжээний жагсаалтыг гаргаж Аялал жуулчлалын хөгжлийн төвд хүргүүлж, байгууллагын веб сайт болон цахим орчинд сурталчилж байна. | 100 % |
| | 3 | Аялал жуулчлалын салбарыг сурталчлах, таниулах аялалын маршрут, шторк, гарын авлага материал боловсруулж, | 2021-2022 | ОНТөсөв, хувийн хэвшил, төсөл хөтөлбөр | Аймгийн аялал жуулчлалын салбарыг сурталчлах Зочид буудал, гэр буудал, | Гарын авлага материал хэвлүүлсэн байна. | Аймгийн аялал жуулчлалын салбарыг сурталчлах Зочид буудал, гэр буудал, аж ахуйн нэгж байгууллагын мэдээлэл, Жуулчны бааз, эвент арга хэмжээний мэдээлэл, түүх, соёл мэдээлэл, үзэсгэлэнт байгалын мэдээлэл, 13 сумын товч танилцуулга, гар урлал, аялал маршрутын | 70 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэвлүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлнэ. | | /6.0/ | аж ахуйн нэгж байгууллагын мэдээлэл, Жуулчны бааз, эвент арга хэмжээний мэдээлэл, түүх, соёл мэдээлэл, үзэсгэлэнт байгалын мэдээлэл, 13 сумын товч танилцуулга, гар урлал, аялал маршрутын мэдээллийг багтаасан гарын авлагын эхийг odko designer ХХК-д 2.5 сая төгрөгөөр бэлтгэж, санхүүжилтийг одоо хүртэл эх бэлтгэлтийн санхүүжилтийг ЗДТГазар шилжүүлээгүй байгаа билээ. | | мэдээллийг багтаасан гарын авлагын эхийг odko designer ХХК-д 2.5 сая төгрөгөөр бэлтгүүлсэн бөгөөд санхүүжилтийг нь одоо хүртэл эх бэлтгэлтийн компанд ЗДТГазар шилжүүлээгүй байгаа билээ. Уг гарын авлагыг Гарман улсын хамтын ажиллагааны “Тусгай хамгаалалттай газар нутгийг түшиглэн экосистемийг хадгалан хамгаалахад хувь нэмрээ оруулах” төсөлтэй хамтран ажиллаж, аялал жуулчлалын танилцуулга гарын авлагыг 500 ширхэг Англи, Монгол хэлтэй хэвлүүлэх санхүүгийн дэмжлэг авч хэвлүүлээд байна. | |
| 3.4.2. Аялал жуулчлалын газрын дэд бүтцийг шийдвэрлэн жуулчдын | 1 | Алтай таван богд уулын тусгай хамгаалалттай газрын Тахилгын овоо хүртэлх замыг сайжруулан засаж, | 2022-2024 | Улсын төсөв, төсөл хөтөлбөр | | | Хэрэгжүүлэх санхүүжилт шийдэгдээгүй байна. | 40 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| аялах таатай нөхцөлийг бүрдүүлнэ. | | ашиглалтад оруулна. | | | | | | |
| | 2 | Аялал жуулчлалын зарим бүсийн эрчим хүчний асуудлыг шийдвэрлэнэ. | 2023-2024 | Улс, орон нутгийн төсөв, 2500.0 | | | Цэнгэл сумын Арал толгойд эрчим хүчний асуудлыг шийдвэрлэхээр аймгийн ЦШСГазар хариуцсан цахилгаан татах ажлыг хийж эхлүүлээд байна. | 70 % |
| | 3 | Эко аялал жуулчлалын орчныг бүрдүүлэх, аялал жуулчлалын нэр бүхий газруудад отоглох, хоноглох цэг байгуулж, хяналтыг сайжруулна. | 2021-2024 | ОНТөсөв, хувийн хэвшил, төсөл хөтөлбөр | | Эко орчин бүрдсэн байна. /2 цэг байгуулна/ | 2022 онд Цэнгэл сумын Хотон, Хурган нуурийн нарийн гүүрийн дэргэд отоглох, хоноглох цэг барих техникийн тодорхойлолтын дагуу, нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж, “Ранго трейвл” ХХК гэрээгээр олгож, гүйцэтгэлийн шат 80 хувьтай хийгдэж байна. | 70 % |
| | 4 | Аялал жуулчлалын бүс нутгийг аялагчдад таниулах тэмдэг, тэмдэглэгээг тавина. | 2021-2024 | ОНТөсөв, хувийн хэвшил 8.0 | | Аялагчдад таниулах тэмдэг, тэмдэглэгээ хийгдсэн байна | Санхүүгийн эх үүсвэр хүрэлцээгүй улмаас хэрэгжээгүй. | 40 % |
| 5.1.1. Орчны бохирдол, хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах бодлого хэрэгжүүлнэ. | 1 | Аймаг болон сумын төвүүдийн бүх байгууллага, ААН-ийг стандартын шаардлага хангасан нэг загварын ангилан ялгах хогийн савтай болгох арга хэмжээ авна. | 2021-2024 | Улсын төсөв, төсөл хөтөлбөр | | Стандартын шаардлага хангасан хогийн савтай болсон байна | Өлгий сумын Аж ахуйн нэгж, ШТС болон Сургуулиудад стандарт хангасан ангилан ялгах хогийн сав хийлгэх шаардлага тавсан ба одоогийн байдлаар 3, 4 дүгээр ЕБСургууль болон 2 ШТСтанц өөрсдийн хөрөнгөөр хогийн сав хийлгэсэн байна. Мөн орон нутгийн хөрөнгөөр ХТАлбанд ундааны сав хэлвэртэй 10 ширхэг ховийн сав хийлгэж стадион болон төв талбайд байршуулсан ба гурван тасалгаатай 2 том оврын хогийн сав хийлгэж байгаа болно. | |
| | 2 | Ахуйн хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр байгуулж, ашиглалтад оруулна. | 2021-2024 | Улс, ОНТ, төсөл хөтөлбөр | | Газрын асуудал шийдвэрлэгдсэн байна. | Төсөв, хөрөнгө байхгүй болохоор хийгдээгүй | |
| 5.1.2. Өлгий сумын агаарын бохирдлыг | 1 | Өлгий сумын агаарын чанарыг сайжруулах бүсийг тогтоож, түүнд мөрдөх журмыг | 2021-2024 | | | Журам батлагдсан байна. | Өлгий сумын агаарын чанарыг сайжруулах бүс тогтоох журмын төслийг боловсруулж, батлуулхаар БОАЖЯаманд хүргүүлсэн болно. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| буурулж, агаарын чанарын хяналтыг сайжруулж “Утаагүй Өлгий” болох бодлого хэрэгжүүлнэ. | | баталж, хэрэгжүүлнэ. | | | | | | |
| | 2 | Айл, өрхийг стандартын шаардлага хангасан сайжруулсан түлшээр хангах, сайжруулсан түлшийг түгээх, тээвэрлэх, борлуулах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллана. | 2021-2024 | Улсын төсөв | | Сайжруулсан түлш үйлдвэрлэх судалгааны ажил хийгдсэн байна. | Хэрэгжээгүй | |
| 5.1.3. Өлгий сумын ногоон байгууламжийг сайжруулах оновчтой менежментийг хэрэгжүүлнэ. | 1 | Нийтийн эзэмшлийн гудамж талбайн ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн хэмжээг нэмэгдүүлж, арчлалт хамгаалалтын менежментийн ажлыг сайжруулна. | 2021-2024 | Улсын төсөв | | Ногоон байгууламжийн хэмжээ 80 га-д хүрсэн байна. | Байгаль орчин, аялал жуулчлалын сайд болон Аймгийн Засаг дарга хооронд 2022 онд хамтран ажиллах гэрээ болон Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө, аймаг, сумдын ИТХуралаар нийт 600.0 сая төгрөгийг ойжуулалт, мод үржүүлэг, мод тарих ажилд зарцуулж байна.<br>Өлгий сумын ногоон байгууламж 114 га-гаар нэмэгдсэн ба ойн зурвас байгуулах ажлыг | 70 % |
| | 2 | Аймгийн төвийн айл өрхүүдийг хашаандаа мод тарих, ногоон байгууламж байгуулах санал санаачлагыг дэмжиж ажиллана. | 2021-2024 | ОНТөсөв, Хувийн хэвшил, төсөл, хөтөлбөр 2.0 | | Иргэдийн санаачлагыг дэмжсэн байна. | СДОАнгийн мод үржүүлгийн талбайн ажлыг дэмжиж трактор, усны цахилгаан насос, бороожуулагчаар хангах 58,5 сая төгрөгийн болон Мод үржүүлгийн газар шинээр байгуулах, Өлгий сумын ард иргэдэд үнэгүй мод өгч хашаанд тариулж иргэдийн санал санаачлагыг дэмжиж ажиллах. Нийт 22000 ширхэг навчид модуудыг иргэн аж ахуйн нэгжүүдэд үнэгүй тарааж өгч мэргэжлийн арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа. | 100 % |
| 5.1.4. Байгалийн унаган төрхөө хадгалсан газар нутгийг | 1 | Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөж, холбогдох мэдээллийн санд бүртгүүлэн баталгаажуулж, | 2021-2024 | | | | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 83 дугаар тогтоолоор Толбо сумын нутагт орших Толбо нуурыг байгалийн унаган төрх, өвөрмөц тогтоц, түүх, соёлын дурсгал, амралт, аялал жуулчлалын ач холбогдол бүхий газар нутгийг хамгаалах, байгалийн нөөц | 100 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| орон нутгийн тусгай хамгаалалтад авна. | | хамгаалалтыг сайжруулна. | | | | | баялгийг зохистой ашиглах зорилготой нуурын эргэн тойрны 19024 га газрыг 20 жилийн хугацаатай орон нутгийн тусгай хамгаалалтад авлаа. | |
| | 2 | Усны нөөцийг бохирдох, хомсдохоос сэргийлж, усны сан бүхий газрыг хамгаалтад авна. | 2021-2024 | | | | Өлгий хотын хүн амын ундны ус хангамжийн баталгаат байдлыг хангуулах зорилгоор аймгийн ИТХурлын ээлжийт 9 дүгээр чуулганд холбогдох бичиг баримтуудыг оруулж Өлгий хотын ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийг батлуулсан.<br>Мөн Баяннуур сумын 3-р багийн нутагт байрлах "Устын рашаан", Ногооннуур сумын "Хавцлын булаг, Алтанцөгц сумын 1-р багийн нутагт "Чихтэйн булагуудын эхийг хамгаалах, ундрага урсацыг сайжруулах ажлыг ажлыг "Нурбах" ХХК хийж гүйцэтгүүлсэн. | 70 % |
| | 3 | Усны тухай хуулийн дагуу 2022 онд аймгийн хэмжээний гадаргын усны тооллого хийнэ. | 2022 | ОНТөсөв 10.0 | 2021 онд тооллого хийгдсэн | | 2022 онд аймгийн хэмжээнд Гол -409, Булаг- 943, Нуур тойром – 1248, Рашаан – 32, гүний худаг -565, гар худаг – 6012, услалтын систем- 16, үерийн хамгаалалтын далан – 4, ширгэсэн гол горхи- 9, ширгэсэн булаг шанд – 28, ширгэсэн нуур тойром – 6 гэж тоологдсон | 100 % |
| 5.1.5. Ойн нөөц, биологийн төрөл зүйлийг хамгаалах, нөхөн сэргээх, ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээ авна.. | 1 | Аймгийн ойн менежментийн төлөвлөгөөг батлуулна. | | | | | 2007 онд батлагдсан Ойн тухай Монгол улсын хуулийн 7-р зүйлийн 7.4.2 дахь заалтийг хэрэгжүүлэх зорилгоор Нэг талаас Баян-Өлгий аймгийн БОАЖГ-аас "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн дагуу "Баян-Өлгий аймаг болон ойн сан бүхий 10 сумын ойн менежментийн төлөвлөгөө хийх ажлын гэрээ" № БОХ 2021/07 дугаартай гэрээг "Мөнх ногоон жодоо" ХХК-тай байгуулж, гүйцэтгүүлэв. | 100 % |
| | 2 | Эко ногоон аймаг болгох зорилт | | | | | Аймгийн хэмжээнд ойн зурвас 10 га, ойжуулалт 30 га газарт тарих ажлыг | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | дэвшүүлж, аймгийн хэмжээнд мод тарих ажлыг өргөжүүлэн шинээр ногоон байгууламжийн бүс байгуулна. | | | | | Монгол уулын ой ХХК гүйцэтгэж байна. Ажлын яьц 70хувтай үргэлжилж байна. ЭКО КЛУБ: БОАЖГ-ын даргын удирдамжийн дагуу аймгийн төвийн сургуулиуд болон Алтанцөгц, Баяннуур, Буянт, Алтай, Ногооннуур, Улаанхус, Цэнгэл, Сагсай, Толбо, Дэлүүн, Булган сум, Цагааннуур /тосгон/, Хөххөтөл, Согоог багуудын ЕБС-ийн 1800 гаруй эко клубуудын сурагчдын дунд “ЭХ ДЭЛХИЙГЭЭ ХАЙРЛАЯ” аян зохион байгуулж, аяны хүрээнд байгаль орчныг хайрлан хамгаалах чиглэлээр “Хөрсний бохирдол”, “Цөлжилт”, “Цэнхэр алт усаа хайрлая”, “Мод тарьж ургуулах аргачлал” сэдэвүүдээр сургалт зохион байгуулж, “Усны үнэ цэнэ” гар зургийн уралдаан, танин мэдэхүйн АХА тэмцээнүүдийг зохион байгуулж, амжилттай оролцож байр эзэлсэн сурагчдыг БОАЖГ-ын өргөмжлөл, мөнгөн шагнал, дурсгалын зүйлээр шагнаж ажиллав.<br>Улаанхус сумын Согоог багийн 2 дугаар сургуульд ажиллаж, БШУГ-ын мэргэжилтэний хамт багш нарын хичээлд сууж, сургуулийн дотуур байртай танилцаж, сурагчдад мэргэжил сонгох сургалт, эко клубын үйл ажиллагаатай танилцаж, байгаль орчныг хамгаалах чиглэлээр сургалтуудыг тус тус зохион байгуулав. Мөн сургуулийн эргэн тойронд эко клубын сурагчдын нэрэмжит ногоон төгөл байгуулах зөвлөгөө өгч 300 ширхэг улиас, бургасны суулгацаар хангалаа. Байгаль дэлхийг хайрлан хамгаалах үүднээс сургуулийн хананд өлгөх 40 ширхэг байгалийн зургийг гардуулан өгч ажиллаа. | % |
| | 3 | Байгалийн баялаг нөөц хамгаалах | 2021-2024 | ОНТөсөв | | | Баруун бүсийн зөвлөгөөн амжилттай зохион байгуулагдсан ба уг зөвлөгөөнд | 100 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | нөхөрлөлүүдийн үйл ажиллагааг чадавхжуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлнэ. | | 4.0 | | | Баян-Өлгий, аймгийн сумуудын удирдлага, байгаль хамгаалагч, ан амьтан хамгаалах нөхөрлөлийн нийт 60 гаруй хүн оролцов. | |
| | 4 | Аймгийн хэмжээний ан, агнуурын менежментийн төлөвлөгөөг батлуулна. | 2022 | ОНТөсөв 60.0 | | | Техникийн тодорхойлолтыг гаргаж орон нутгийн өмчийн газарт хүргүүлж тендер зарлаж байна. 2023 онд аймгийн хэмжээний агнуурын бүс нутгаас Алтайн угалз-31, алтайн тэх-40, Халиун буга-5, зэгсний зэрлэг гахай-10 толгой агнуулах саналыг Байгаль орчин, аялал жуулчлалын газарт хүргүүлсэн. | 70 % |
| 5.1.6. Байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй үйлдвэрлэл, үйлчилгээ болон байгалийн нөөцийн хууль бус ашиглалтад тавих хяналтыг сайжруулна. | 1 | Байгалийн нөөцийн хууль бус ашиглалтад тавих хяналтыг хууль хяналтын байгууллага, хамтрагч талуудын оролцоотойгоор хэрэгжүүлнэ | 2021-2024 | | Байгаль орчны эсрэг гэмт хэргийн зөрчлийг бууруулах зорилгоор байгаль орчны салбар болон хууль хяналтын байгууллагуудтай хамтран нэгдсэн хяналт шалгалтыг 4 удаа ажлын удирдамжын дагуу зохион байгууллаа. Үүнд Алтай Таван богдын байгалийн цогцолборт газрын Хотон нуур, Хуурган нуур, | | Байгаль орчны эсрэг гэмт хэргийн зөрчлийг бууруулах зорилгоор байгаль орчны салбар болон хууль хяналтын байгууллагуудтай хамтран нэгдсэн хяналт шалгалтыг 3 удаа ажлын удирдамжын дагуу зохион байгууллаа.<br>Үүнд: Бугат, Ногооннуур, Алтанцөгц, Баяннуур сумуудын ойн сан бүхий газруудад хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын ажлыг тус тус хийж гүйцэтгэв.<br>Алтанцөгц, Алтай, Баяннуур, Ногооннуур, Буянт, Дэлүүн, Толбо, Булган сумуудын Засаг дарга нарт Байгалийн баялагийг ашигласны төлбөрийг эргүүлэн байгаль орчинд зарцуулах, Засгийн газрын 02 тогтоолыг таницуулж ажиллаа. | 100 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Даяннуур, Ховд голын сав газрын дагуух, Алтанцөгц, Баяннуур сумуудын ойн сан бүхий газруудад хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын ажлыг тус тус хийж гүйцэтгэв. Уг шалгалтын арга хэмжээний үеээр эрүүгийн хэргийн шинжтэй нэг зөрчил илэрүүлж аймгийн цагдаагийн газарт шилжүүлэн шаалгуулж байна. | | | |
| | 2 | Хавар, намрын хуурайшилт ихтэй үед ой, хээрийн түймэр гарахаас урьдчилан сэргийлэх | 2021-2024 | | Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах | | хавар намрын хэт их хуурайшилттай үед ойгоос мод бэлтгэх, ойн дагалт нөөц ашиглах, аялал зугаалгыг хязгаарлах, сум орон нутгийн аж ахуй нэгж албан байгууллага, ойн нөхөрлөл, иргэдэд | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | сурталчилгааг мэдээллийн бүхий л хэрэгслээр ард иргэдэд хүргэнэ. | | | тухай Улсын онцгой комиссийн 2021 оны 03-р сарын 01-ний өдрийн 02 тоот албан даалгаварын хүрээнд зохион байгуулах зарим арга хэмжээний төлөвлөгөө гаргаж сумдад хүргүүлж албан даалгаварын хүрээнд хавар намрын хэт их хуурайшилттай үед ойгоос мод бэлтгэх, ойн дагалт нөөц ашиглах, аялал зугаалгыг хязгаарлах, сум орон нутгийн аж ахуй нэгж албан байгууллага, ойн нөхөрлөл, иргэдэд түймэрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах | | түймэрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах талаар ухуулга, сурталчилгаа зохион байгууллаж брошуур тарааж ажиллаж байна. Байгаль хамгаалагчдад хариуцсан нутаг дэвсгэртээ тавих хяналтаа сайжруулах, эргүүл хяналт шалгалтын ажлаа эрчимжүүлэх талаар үүрэг чиглэл өгч байнгын эргүүл пост ажиллуулж байна.<br>Алтанцөгц, Баяннуур, Буянт, Алтай, Ногооннуур, Улаанхус, Цэнгэл, Сагсай, Толбо, Дэлүүн, Булган сум, Цагааннуур /тосгон/ сумдын ард иргэдэд Байгаль орчны нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж байгаль хамгаалах тухай хуулийг сурталчилж ажиллаа. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | талаар ухуулга, сурталчилгаа зохион байгууллаж боршуур тарааж ажиллаж байна. Байгаль хамгаалагчдад хариуцсан нутаг дэвсгэртээ тавих хяналтаа сайжруулах, эргүүл хяналт шалгалтын ажлаа эрчимжүүлэх талаар үүрэг чиглэл өгч байнгын эргүүл пост ажиллуулж байна. | | | |
| 6.1.2. Хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх, төвлөрсөн цэгт булах, хог хаягдлын хэмжээг бууруулж, хөрсний бохирдлыг бууруулах, | 1 | Өлгий сумд хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах, дэд бүтцийн тохижилтын ажлыг шат дараатай хэрэгжүүлнэ. | 2021-2023 | Улс, орон нутгийн төсөв, төсөл, хөтөлбөр | Азийн хөгжлийн банк судалгааны ажил явуулж байна. | | Өлгий сумын төвд Сандитис ХХК стандартын дагуу эмнэлгийн аюултай болон эрсдэлтэй хог хаягдлыг тээвэрлэх, халдваргүйжүүлэх, устгах үйл ажиллагаа явуулах үйлдвэрийг байгуулсан. Тус компан нь зөвшөөрөл бүхий эрүүл мэндийн байгууллагуудтай гэрээ хийж устгалын ажил явуулж байна. | 70 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Өлгий сумын гэрэлтүүлэг, камержуулалт зэрэг дэд бүтцийн тохижилтын ажлыг сайжруулна. | | | | | | | | |

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР